



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 24 эдэр

Дугаар 27

Есөнбулаг сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 36 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын Утга зохиолын нэрт төлөөлөгч, төр нийгмийн зүтгэлтэн Чадраабалын Лодойдамбын мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх аймгийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Т.Ганзориг /Аймгийн ИТХ-ын дарга/

Нарийн бичгийн дарга: Ч.Бат-Эрдэнэ /ЗДТГ-ын дарга/

Гишүүдэд: С.Гансэлэм /Аймгийн Засаг дарга/

Ж.Ганбат /Засаг даргын орлогч/

А.Мөнхтөр /ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн

бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/

Ч.Жаргалсайхан /Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга/

М.Эрдэнэбилэг /Нийгмийн бодлогын хэлтсийн дарга/

Р.Батмөнх /Боловсрол, соёл урлагийн газрын дарга/

Н.Бямбацогт /Биеийн тамир, спортын газрын дарга/

С.Болормаа /Хүүхэд, гэр бүл залуучуудын

хөгжлийн газрын дарга/

Н.Энхбат /Ардын дуу бүжгийн Алтай чуулгын дарга/

Х.Батболд /12 жилийн 2-р сургуулийн захирал/

Э.Оюунгэрэл /Нийтийн номын сангийн дарга/

Ш.Цоодол /Алтай радиогийн сурвалжлагч/

Ц.Оюунзул /Орон нутгийг судлах музейн дарга/

2. Ойн арга хэмжээнд зарцуулагдах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

3. Төрийн хошой соёрхолт, эрдэмтэн зохиолч Ч.Лодойдамбын мэндэлсний түүхт 100 жилийн ойг тэмдэглэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, зохион байгуулалтын өндөр түвшинд тэмдэглэн өнгөрүүлэхийг комиссын дарга /Т.Ганзориг/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ